



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/530

Ховд

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "е", 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 48 дугаар тушаалаар батлагдсан "Агаарын хөлгийн шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Ховд аймаг дахь "Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

2.Энэ захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/378 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

Зөвлөлийн дарга: -Аймгийн Засаг даргын Эдийн засаг, хөгжлийн бодлого хариуцсан орлогч


Гишүүд:

- Ховд хотын ерөнхий архитектор
- Ховд аймаг дахь Нисэх буудлын дарга
- Ховд аймаг дахь Нисэх буудлын нислэгийн удирдагч
- Ховд аймаг дахь нисэх буудлын аэродромын техникч
- “Аэро Монголиа” ХХК-ний Ховд дахь төлөөлөгч
- “Хүннү эйр” ХХК-ний Ховд дахь төлөөлөгч
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Жаргалант сумын Хот тохижуулах газрын дарга

Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. “Агаарын хөлөг шувуу мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл”-ийн Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалтад хуулийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

